ЦССҮТ-ийн Захирлын 2026 оны
01 дүгээр сарын 09-ний өдрийн
А/03 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН МАЯГТ

## I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☑ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

| | |
|---|---|
| Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: | **Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/463 дугаар тушаал** |
| Дагаж мөрдөх огноо: | **2025.12.08** |
| Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: | 2026.01.09 |

| | |
|---|---|
| Байгууллагын нэр: | Нэгжийн нэр: |
| **Цус сэлбэлт судлалын Үндэсний төв** | **Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба** |
| Албан тушаалын нэр: | Албан тушаалын ангилал, зэрэглэл: |
| **Албаны дарга** | **ТҮЭМ-7** |
| Ажлын цаг: | Ажлын байрны албан ёсны байршил: |
| **08:30-17:30** | **БЗД 3 дугаар хороо ЦССҮТ-ийн байр** |
| Хөдөлмөрийн нөхцөл: | Онцгой нөхцөл: |
| Хэвийн | |

## II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

**Албан тушаалын зорилго:**
Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулах, чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, албаны үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, тогтвортой байдлыг хангах, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлтэй холбоотой хууль тогтоомж бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангуулах, гүйцэтгэлийн үнэлгээ хийх, тайлагнах.

**Албан тушаалын зорилт**:

1. Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулах
2. Чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх
3. Албаны үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, тогтвортой байдлыг хангах
4. Тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдал, эрсдэлтэй холбоотой хууль тогтоомж бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангуулах, гүйцэтгэлийн үнэлгээ хийх, тайлагнах
5. Сувилахуйн тусламж үйлчилгээ, үндсэн үйл ажиллагааны мэдээ тайлан нэгтгэх, эмнэлгийн тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах үйл ажиллагаа зохион байгуулалтын удирдлагаар хангах;
6. Чанар, ХЭМАБ-ын удирдлагын тогтолцоог үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн

| | | | |
|---|---|---|---|
| тасралтгүй сайжруулах. | | | |
| **Зорилт** | **Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг** | **Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт** | **Хариуцлага, оролцооны хэлбэр** Туслах - **Т**, Хариуцан гүйцэтгэх - **Г** Хянах – **Х** Шийдвэрлэх – **Ш** |
| 1 дүгээр зорилтын хүрээнд | -Байгууллагын зорилго, үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах, үнэлэлт дүгнэлт өгөх. | -Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь (%),<br>-Чанар, аюулгүй байдлын үнэлгээ, дүн шинжилгээ хийсэн тайлангийн тоо (жил/улиралд),<br>-Илэрсэн эрсдэл, зөрчлийн бууралтын хувь (өмнөх үетэй харьцуулсан); | **Г,Х** |
| | -Тусламж, үйлчилгээний стандарт, журам зааврын мөрдөлтийн хэрэгжилтийг хангуулж, удирдан зохион байгуулах арга хэмжээг хэрэгжүүлэх | -Стандарт, журам мөрдөлтөд хяналт хийсэн албаны хамрагдалтын хувь (%),<br>-Стандарт зөрчсөн тохиолдлын тоо (улирал/жилд),<br>-Илэрсэн зөрчлийг арилгасан хэрэгжилтийн хувь (%),<br>-Сургалт, зааварчилгаанд хамрагдсан ажилтны хувь; | **Г,Х** |
| | -Хөндлөнгийн хяналт, шинжилгээ, үнэлгээ, магадлан итгэмжлэл, салбарын хяналтын шалгалтын дүн, | -Хөндлөнгийн хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн хувь (%), | **Г, Х** |

| | | | |
|---|---|---|---|
| | зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах | -Магадлан итгэмжлэл, шалгалтаар хангалттай үнэлгээ авсан үзүүлэлтийн хувь,<br>-Давтан илэрсэн зөрчлийн тоо,<br>-Зөвлөмж хэрэгжүүлэх төлөвлөгөө баталж, тайлагнасан тоо; | |
| | -Төвийн тусламж, үйлчилгээтэй холбоотойгоор иргэд, байгууллагаас ирсэн санал, гомдол, хүсэлтийг шийдвэрлүүлэх ажлыг хамтран ажиллах, тэдний хүсэлтийг шийдвэр гаргалтад тусгасан талаар эргэн мэдээлэх | -Хүлээн авсан санал, гомдлын шийдвэрлэлт (%),<br>-Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн гомдлын хувь,<br>-Иргэнд эргэн мэдээлэл өгсөн тохиолдлын хувь,<br>-Давтан гомдлын тоо (бууралтын хувь); | **Г,Х** |
| | -Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр санал боловсруулан удирдах, зөвлөл, удирдлагад танилцуулан шийдвэрлүүлэх | -Боловсруулж танилцуулсан санал, зөвлөмжийн тоо,<br>-Удирдлага, зөвлөлөөр батлагдсан саналын хувь,<br>-Хэрэгжсэн сайжруулалтын арга хэмжээний тоо,<br>-Сайжруулалтын дараах чанарын үзүүлэлтийн өсөлтийн хувь; | **Г,Х** |
| | -Төвийн тусламж, үйлчилгээний чанарын асуудлаар төр ба ТББ, мэргэжлийн нийгэмлэг, иргэнтэй хамтран ажиллах | -Хамтын ажиллагааны уулзалт, хэлэлцүүлгийн тоо,<br>-Хамтран хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний тоо,<br>-Хамтын ажиллагааны үр дүнд хэрэгжсэн сайжруулалтын тоо; | **Г,Х** |
| 2 дугаар зорилтын хүрээнд | -Төвийн хэмжээнд чанар, аюулгүй байдлын чиглэлээр ажиллаж буй орон тооны бус багийн төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлгээ | -Багийн батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь (%),<br>-Төлөвлөгөөний дагуу хийгдсэн үйл ажиллагааны тоо (улирал/жилд), | **Т, Г,Х** |

| | | | |
|---|---|---|---|
| | өгөх, үйл ажиллагааны хэвийн байдлыг хангахад дэмжлэг туслалцаа үзүүлэх | -Дэмжлэг, зөвлөгөө үзүүлсэн уулзалт, зөвлөмжийн тоо,<br>-Төлөвлөгөөний хэрэгжилтээс үүдэлтэй чанарын үзүүлэлтийн сайжралтын хувь, | |
| | -Төвд шинээр орсон эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд мэргэжлийн зайлшгүй шаардлагатай чиг баримжааг таниулах ажлыг зохион байгуулах | -Чиг баримжаа олгох сургалтад хамрагдсан шинэ ажилтны хувь (%),<br>-Сургалт зохион байгуулсан давтамж (сар/улирал),<br>-Чиг баримжаа олгох хөтөлбөрийн агуулгын бүрэн хэрэгжилт (%),<br>-Шинэ ажилтны сэтгэл ханамжийн түвшин (%); | Т, Г,Х |
| | -Төвийн чанар, аюулгүй байдлын багийг зохион байгуулан гишүүдийг томилж байгууллагын ажилтнуудын албан тушаалын тодорхойлолд чанар, аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр тусган, чиг үүргийн дагуу ажиллуулах | -Чанар, аюулгүй байдлын багийг албан ёсоор байгуулж, гишүүдийг томилсон байх,<br>-Албан тушаалын тодорхойлолтод чанар, аюулгүй байдлын чиг үүрэг тусгагдсан ажилтны хувь (%),<br>-Багийн хурал, уулзалтын тоо,<br>-Багийн шийдвэр, саналын хэрэгжилтийн хувь; | Г,Х |
| | -Бүх шатны менежерүүд, бусад ажилтны ажлыг гүйцэтгэлийн үнэлгээнд чанар, аюулгүй байдлын чиглэлээр хийсэн ажлыг | -Гүйцэтгэлийн үнэлгээний шалгуурт чанар, аюулгүй байдлын үзүүлэлт тусгагдсан албан тушаалын хувь<br>-Үнэлгээний шалгуурыг батлуулсан баримт бичгийн тоо | Г,Х |

| | | | |
|---|---|---|---|
| | үнэлэх шалгуурыг хянах, батлуулах | -Үнэлгээний явцад чанар, аюулгүй байдлын үзүүлэлтээр үнэлэгдсэн ажилтны хувь<br>-Үнэлгээтэй холбоотой маргаан, гомдлын тоо | |
| | -Чанар, аюулгүй байдлын чиглэлээр үр дүнтэй ажилласан ажилтан, алба, баг,хороог урамшуулал олгох, шагнах, дэмжлэг үзүүлэх тухай саналыг оруулах | -Урамшуулал, шагналд нэр дэвшүүлсэн саналын тоо<br>-Удирдлагаар батлагдсан урамшууллын саналын хувь (%)<br>-Урамшуулал авсан ажилтан, багийн тоо<br>-Урамшууллын дараах ажлын идэвх, чанарын үзүүлэлтийн өсөлт (%) | **Г,Х** |
| | -Ажлын гүйцэтгэлийн үнэлгээгээр чанар аюулгүй байдлын чиглэлээр хангалтгүй үнэлүүлсэн ажилтан, алба, баг, хороог холбогдох журмын дагуу хариуцлага тооцох саналыг байгууллагын удирдлагын зөвлөлд танилцуулах | -Хангалтгүй үнэлгээ авсан ажилтан, багийн тоо<br>-Холбогдох журмын дагуу боловсруулж танилцуулсан хариуцлагын саналын тоо<br>-Удирдлагын зөвлөлөөр хэлэлцэгдсэн саналын хувь<br>-Давтан хангалтгүй үнэлгээ авсан тохиолдлын бууралтын хувь | **Г,Х,Ш** |
| | -Нэгдсэн менежментийн тогтолцооны тасралтгүй хэвийн байдлыг хангаж ажиллана. | -Нэгдсэн менежментийн тогтолцооны дотоод аудитын тоо<br>-Илэрсэн зөрчил, үл тохирлын тоо (бууралтын хувь)<br>-Засах, сайжруулах арга хэмжээний хэрэгжилтийн хувь (%)<br>-Тогтолцооны тасралтгүй сайжруулалтын тайлан | **Г,Х,Ш** |

| | | | |
|---|---|---|---|
| 3 дугаар зорилтын хүрээнд | -ТҮЧАБ-ын албыг чанарын удирдлагаар хангаж, чанарын бүх үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах, үр дүнг тооцох | -Албаны жилийн төлөвлөгөө батлагдсан эсэх (тийм/үгүй)<br>-Төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь (%)<br>-Дотоод үнэлгээ, чанарын дүн шинжилгээ хийсэн тайлангийн тоо<br>-Илэрсэн зөрчил, эрсдэлийн бууралтын хувь<br>-Сайжруулах арга хэмжээний хэрэгжилтийн хувь (%)<br>-Чанарын үзүүлэлтүүдийн (алдаа, эрсдэл, гомдол) ээрэг өөрчлөлтийн хувь | Г,Х,Ш |
| | -Тархвар судлал, хүний нөөц, лаборатори, сувилахуй, санхүү, аж ахуй, орон тооны бус алба, баг, зөвлөл болон албуудын уялдаа холбоог хангаж, чанар сайжруулах үйл ажиллагаанд хамт олны оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэн ажиллах | -Чанар сайжруулах чиглэлээр хамтарсан уулзалт, хурал, зөвлөгөөний тоо<br>-Чанарын үйл ажиллагаанд оролцсон алба, багийн хамрагдалтын хувь (%)<br>-Хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжсэн санал, шийдвэрийн хэрэгжилтийн хувь | Г,Х,Ш |
| | -Шинээр ажилд орсон эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдлийн чиглэлээр сургаж чадавхжуулах ажлыг тогтмол зохион байгуулахад чанар, аюулгүй байдлын албаны оролцоог хангах | -Чанар, аюулгүй байдал, эрсдлийн чиглэлээр сургалтад хамрагдсан шинэ ажилтны хувь (%)<br>-Сургалт зохион байгуулсан давтамж (сар/улирал)<br>-Сургалтын дараах мэдлэгийн үнэлгээний дундаж оноо<br>-Шинэ ажилтантай холбоотой чанар, аюулгүй байдлын зөрчлийн тоо (бууралтын хувь) | Г,Х |

| | | | |
|---|---|---|---|
| | -Байгууллагын удирдлага, эмч ажилтны ажлын байрны тодорхойлолтод тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг чиглэлээр хийх ажлыг тусгаж, ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд чанар аюулгүй байдлын чиглэлээр хийсэн ажлыг үнэлэх | -Ажлын байрны тодорхойлолтод чанар, аюулгүй байдлын чиг үүрэг тусгагдсан албан тушаалын хувь (%)<br>-Гүйцэтгэлийн үнэлгээний шалгуурт чанар, аюулгүй байдлын үзүүлэлт тусгагдсан ажилтны хувь<br>-Чанар, аюулгүй байдлын үзүүлэлтээр үнэлэгдсэн ажилтны тоо<br>-Үнэлгээний үр дүнд сайжруулах арга хэмжээ авсан тохиолдлын хувь<br>-Үнэлгээтэй холбоотой гомдол, маргааны тоо | Г,Х |
| | -Тусламж, үйлчилгээний чанар, эрсдэл аюулгүй байдлыг сайжруулах дэлгэрүүлэх, чанарын өдөрлөг, туршлага судлах, судлуулах, зэрэг ажлуудыг зохион байгуулж, үр дүнг тооцох | -Чанарын өдөрлөг, сургалт, туршлага солилцох арга хэмжээний тоо<br>-Арга хэмжээнд хамрагдсан эмч, ажилтны хувь (%)<br>-Туршлага судалсан, судлуулсан байгууллага, нэгжийн тоо<br>-Арга хэмжээний үр дүнд хэрэгжсэн сайжруулалтын саналын тоо<br>-Арга хэмжээний дараах чанарын үзүүлэлтийн сайжралтын хувь | Г,Х,Ш |
| 4 дүгээр зорилтын хүрээнд | -Байгууллагад тохиолдож болох аюул ослыг тодорхойлж тооцоолох, аюул осолд хүргэж болох хүчин зүйлсийг илрүүлэх, эрсдэлийг бууруулах, арилгах, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.<br><br>-Эрсдэл нүүрэлсэн тохиолдолд түүнийг хохирол багатайгаар даван туулах, ирээдүйд учирч болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, эрсдлээс ангид байх ажлуудыг | -Илрүүлж үнэлсэн эрсдэлийн тоо<br>-Эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан албаны хувь (%)<br>-Эрсдэл бууруулах төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь<br>-Өндөр эрсдэлийн тохиолдлын бууралтын хувь<br>-Эрсдэлийн хариу арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан эсэх<br>-Эрсдэлтэй нөхцөлд авсан хариу арга хэмжээний хугацаа (дундаж) | Г,Х<br><br>Г,Х |

1118266548 ... 9128905

| | | | |
|---|---|---|---|
| | зохион байгуулах. | -Давтан тохиолдсон ижил эрсдэлийн бууралтын хувь<br>-Урьдчилан сэргийлэх сургалт, дадлагын тоо | |
| | -Эмнэлзүйн эрсдлийн түүх, мэдээний сан ажиллуулах, тохиолдлын үндсэн шалтгааны дүн шинжилгээ хийх, урьдчилан сэргийлэх, бууруулах, ажлыг зохион байгуулах | -Бүртгэгдсэн эмнэлзүйн эрсдлийн тохиолдлын тоо<br>3.2 Үндсэн шалтгааны дүн шинжилгээ (RCA) хийсэн тохиолдлын хувь<br>3.3 Дүн шинжилгээнд үндэслэн хэрэгжүүлсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээний тоо<br>3.4 Давтан эрсдэлийн тохиолдлын бууралтын хувь | Г,Х |
| | -Халдварын хяналт, сэргийлэлтийн үндсэн шаардлагуудын мөрдөлтөд хяналт тавих, мэргэжил арга зүйгээр удирдах | --Халдварын хяналтын сэргийлэлтийн журмын мөрдөлтийн түвшин (%)<br>-Хяналт үнэлгээнд хамрагдсан албаны хувь<br>-Халдварын дэглэм зөрчсөн тохиолдлын тоо<br>-ЭТҮХХ-ын халдварын тоо | Г,Х |
| | -Эмнэлгийн тулгамдсан асуудал болон эрсдэл өндөр тасаг/ нэгжийг тогтоох, шийдвэрлүүлэх | -Эрсдэл өндөр гэж тодорхойлсон нэгжийн тоо<br>-Удирдлагад танилцуулсан санал, шийдвэрийн тоо<br>-Шийдвэрлэгдсэн асуудлын хэрэгжилтийн хувь | Г,Х,Ш |
| | -Үйлчлүүлэгч, эмнэлгийн ажилтны аюулгүй байдал, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн тогтолцоо, зохион байгуулалтын талаар санал гаргах, шийдвэрлүүлэх, үр дүнг тооцох | -Үйлчлүүлэгч, эмнэлгийн ажилтны аюулгүй байдал, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны тоо, хэрэгжилтийн хувь<br>-Үйлчлүүлэгч, эмнэлгийн ажилтны аюулгүй байдалтай холбоотой осол, гэмтлийн тоо<br>-Үйлчлүүлэгч, ажилтны аюулгүй байдлын сэтгэл ханамж (%)<br>-Хамтарсан үнэлгээ хийсэн тоо 7.2 Үнэлгээнд хамрагдсан холбогдох алба, мэргэжилтний тоо 7.3 Үнэлгээний | Г,Х |

| | | | |
|---|---|---|---|
| | -Эмнэлгийн гадаад, дотоод орчин болон эмнэл зүйн аюулгүй байдалд холбогдох алба, мэргэжилтэнтэй хамтран үнэлгээ хийж, зөвлөмжийн хэрэгжилтийгг хангуулах<br><br>-Үйлчлүүлэгчийн аюулгүй байдалтай холбоотой тохиолдлыг бүртгэх, мэдээлэх, дүн шинжилгээ хийх, хариу арга хэмжээ авах, эргэн мэдээлэх/ цаасан болон цахим тогтолцоог цогцоор нь хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах<br><br>-Төвийн орчинд үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж буй гадаад дотоод орчны эрсдэл нөхцөл байдал, эмнэл зүйн эрсдэлийг илрүүлэн бүртгэх тогтолцоог бий болгон эрсдэлийг эрэмбэлэх, үнэлэх хариу арга хэмжээ авах ажилд дэмжлэг үзүүлэх<br><br>-Үйлчлүүлэгчийн санал , гомдол, сэтгэл ханамжийн судалгааг зохих журмын дагуу авах, судалгааны үр дүнг шийдвэр гаргалт, төлөвлөлтөд ашиглах, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг эргэн мэдээлэх ажлыг зохион байгуулна. | зөвлөмжийн хэрэгжилтийн хувь<br>-Бүртгэгдсэн тохиолдлын тоо -Хугацаанд нь дүн шинжилгээ хийж хариу арга хэмжээ авсан хувь<br><br>-Илрүүлж бүртгэсэн гадаад, дотоод орчны эрсдэлийн тоо -Эрсдэлийг эрэмбэлж үнэлсэн хувь<br>9.3 Өндөр эрсдэлд авсан хариу арга хэмжээний хэрэгжилтийн хувь<br>-Эрсдэлийн түвшний бууралтын хувь<br>-Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо-Санал, гомдлыг хугацаанд нь шийдвэрлэсэн хувь<br>-Судалгааны үр дүнд үндэслэн гаргасан шийдвэрийн тоо<br>-Эргэн мэдээлсэн тохиолдлын хувь<br>-Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн түвшин (%)<br>-Мэдээллийн санг тогтмол шинэчилсэн давтамж<br>-Журмын дагуу хийсэн дүн шинжилгээний тайлангийн тоо<br>-Мэдээлэлд үндэслэн авсан сайжруулах арга хэмжээний тоо<br>-Үйл ажиллагааны зохион байгуулалтад хийсэн хяналтын тоо<br>-Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь<br><br>-Лавлагаа мэдээллийн чиглэлээр хэрэгжүүлж буй журмын хэрэгжилтийн хувь (%) | Г,Х<br><br>Г,Х<br><br>Г,Х<br><br>Г,Х,Ш |

| | | | |
|---|---|---|---|
| | -Чанар аюулгүй байдлын мэдээний санг тогтмол ажиллуулан журамд заасны дагуу дүн шинжилгээ хийх, эргэн мэдээлэх ажилд хяналт тавих | -Зорилтот бүлэгт зориулсан хүртээмжтэй орчны сайжруулалтын тоо 13.3 Лавлагаа мэдээлэлтэй холбоотой гомдлын тоо | Х |
| | -Цус цуглуулах, шинжлэх, үйлдвэрлэх, хадгалах, түгээх үйл ажилгааны зохион байгуулалтанд хяналт тавих | | Г,Х |
| | -Үйлчлүүлэгчид хүргэж байгаа лавлагаа мэдээллийн үйлчилгээнд хяналт тавих, зорилтот бүлгийн үйлчлүүлэгчийн тусгай хэрэгцээ, шаардлагыг хангасан орчин бүрдүүлэх | | Г,Х |

| | | | |
|---|---|---|---|
| 5 дугаар зорилтын хүрээнд | -Сувилахуйн тусламж, үйлчилгээг нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих | -Сувилахуйн үйл ажиллагаанд хийсэн хяналтын тоо<br>-Сувилахуйн үйл ажиллагааны журам, стандарт мөрдөлтийн хувь (%)<br>-Сувилахуйн үйл ажиллагаатай холбоотой тохиолдлын тоо<br>-Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж (%) | Х |
| | -Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, бэлэн байдлыг хангах үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих | -Төлөвлөгөөт засвар, урьдчилсан хяналтын хэрэгжилтийн хувь (%)<br>-Тоног төхөөрөмжийн доголдол, алдаа(%)<br>-Засвар үйлчилгээ, ашиглалтын САЗ-ын хэрэгжилтийн (%)<br>-Засвар, хяналтын тайланг сар тутам гаргасан байдал | Х |
| | -Үндэсний хэмжээний цус сэлбэлт судлалын статистик мэдээ тайланд дүн шинжилгээ хийх, тайлагнах | -Судалгааны мэдээллийг бүрэн цуглуулсан хувь (%)<br>-Дүн шинжилгээний үнэн зөв байдал (%)<br>3.3 Тайланг батлагдсан хугацаанд хүргүүлсэн хувь (%)<br>-Тайлангийн үр дүнг бодлого, төлөвлөлтөд ашигласан хувь | Х |
| 6 дугаар зорилтын хүрээнд | -Чанар, ХЭМАБ-ын удирдлагын тогтолцоог үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн тасралтгүй сайжруулан ажиллах | -Чанар, ХЭМАБ-ын удирдлагын тогтолцоог тасралтгүй сайжруулсан арга хэмжээний хэрэгжилтийн хувь<br>-ЧМТ, ХЭМАБ чиглэлээрх аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хянаж, бүрэн биелсэн хувь (%)<br>-Албаны тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах шаардлагатай нөхцөлүүдийг бүрдүүлсэн байдал (ажиллагсдын сэтгэл ханамжийн үнэлгээ) | Г,Х |

| | | | |
|---|---|---|---|
| | | -Албаны чанарын шалгуур үзүүлэлтийг улирал бүр үнэлж, дүгнэсэн хувь (%)<br>-Үндсэн үйл ажиллагааны тоо баримтад сар, улирал тутам дүн шинжилгээ хийсэн хувь (%)<br>-Тохиолдлын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж, засах, сэргийлэх ажлыг зохион байгуулсан хувь (%)<br>-Учирч болох эрсдлийг тодорхойлж, үнэлэн, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн хувь (%) | |

| III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА | | |
|---|---|---|
| **Боловсрол** | Бакалавр түүнээс дээш боловсролын зэрэгтэй. | |
| **Мэргэжил** | Хүний их эмч | |
| **Мэргэшил** | Эмнэлзүйн цус сэлбэлт судлал болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын чиглэлээр төрөлжсөн мэргэшил эзэмшсэн байх | |
| **Туршлага** | Төрийн албанд 8-аас доошгүй, түүнээс эрүүл мэндийн салбарын удирдах албан тушаалд болон цус сэлбэлт судлалын салбарт 2-оос доошгүй жил ажилласан. | |
| **Ур чадвар** | Удирдан зохион байгуулах | • Байгууллагын стратеги, бодлого, зорилгыг албаны үйл ажиллагаанд тусган төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнг үнэлэх;<br>• Албаны жилийн, улирлын болон богино хугацааны төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийг хангах;<br>• Албаны хүний нөөц, санхүү, материаллаг нөөцийг оновчтой зохион байгуулах;<br>• Ажилтнуудын үүрэг, хариуцлагыг тодорхойлж, ажлын уялдаа холбоог хангах;<br>• Дотоод журам, стандарт, зааврын хэрэгжилтийг албаны түвшинд зохион байгуулах;<br>• Хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмол хийж, үр дүнг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх. |
| | Дүн шинжилгээ хийх | • Албаны үйл ажиллагааны гүйцэтгэл, чанар, аюулгүй байдлын үзүүлэлтэд дүн шинжилгээ хийх;<br>• Тайлан, мэдээ, судалгаа, статистик мэдээлэлд үндэслэн нөхцөл байдлыг үнэлэх; |

| | | |
|---|---|---|
| | | • Эрсдэл, боломжийг тодорхойлон сайжруулах санал боловсруулах;<br>• Дотоод хяналт, аудит, үнэлгээний дүнг задлан шинжилж, сайжруулах төлөвлөгөө боловсруулах;<br>• Үндэсний болон дотоод статистик мэдээллийг цуглуулж, боловсруулж, дүн шинжилгээ хийх, сан үүсгэх;<br>• Чанарын үзүүлэлт, гүйцэтгэлийн шалгуурыг тогтмол хянаж дүгнэлт хийх. |
| | Асуудал шийдвэрлэх | • Албаны хэмжээнд үүссэн болон үүсэж болзошгүй асуудлыг цаг тухайд нь илрүүлж, шийдвэрлэх;<br>• Эрсдэл, зөрчлийг урьдчилан тооцоолж, сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;<br>• Үйл ажиллагааны доголдол, зөрчлийг холбогдох хууль, дүрэм, стандартын хүрээнд шийдвэрлэх;<br>• Хүний нөөцтэй холбоотой асуудлыг хүнлэг, шударга, ил тод, ёс зүйтэйгээр шийдвэрлэх;<br>• Яаралтай болон онцгой нөхцөлд шийдвэр гаргах, зохион байгуулалт хийх. |
| | Манлайлах | • Баг хамт олныг нэг зорилгын төлөө чиглүүлж, урам зориг өгөх;<br>• Ёс зүй, хариуцлага, сахилга баттай манлайллын үлгэр үзүүлэх;<br>• Ажилтнуудын ур чадвар, чадамжийг хөгжүүлэх, сургалт, дадлагыг дэмжих;<br>• Шинэ санал санаачилга, тасралтгүй сайжруулалтын соёлыг төлөвшүүлэх;<br>• Хамтын ажиллагаа, эерэг уур амьсгалыг төлөвшүүлэх. |
| | Бусад | • Албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах, тайлагнах, мэдээлэл солилцоог зохион байгуулах;<br>• Монгол бичгээр унших, ойлгох, ашиглах чадвартай байх;<br>• Мэргэжлийн үйл ажиллагаанд шаардлагатай компьютерийн программ болон мэдээллийн технологийг ашиглах;<br>• Жендер, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг хүний эрхийн холбогдох хууль, дүрэм журмыг хэрэгжүүлэх;<br>• Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чадвартай байх, хууль, дүрэм журмыг сахин мөрдөх;<br>• Онлайн харилцааг ашиглан мэдээлэл солилцох, мэдээллийг шуурхай хүргэх;<br>• Үйлчилгээний стандарт, журмын хэрэгжилтийг албаны түвшинд хангах; |

1118266548 ...9128905

| | | |
|---|---|---|
| | | • Байгууллагын нэр хүнд, харилцаа холбоог хамгаалж, үр дүнтэй харилцааг тогтоох;<br>• Мэдээллийн нууцлал, аюулгүй байдал, ёс зүйн шаардлагыг хангаж ажиллах;<br>• Гадаад хэлээр албан ёсны мэдээлэл, эх сурвалжийг унших, ойлгох, ашиглах чадвартай байх;<br>• Дотоод болон гадаад байгууллагатай үр дүнтэй хамтран ажиллах;<br>• Үйл ажиллагааны үр дүн, чанарын үзүүлэлт, дотоод хяналт, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлилтийг хангах, зохион байгуулах чадвартай байх. |

| IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ | |
|---|---|
| Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: | |
| ЦССҮТ-ийн Захирал | |
| Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:<br>1. Чанарын менежер -1<br>2. Аюулгүй байдал, эрсдэл хариуцсан менежер-1<br>3. Сувилахуйн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн -1<br>4. Халдар судлаач, ХЭМАБ хариуцсан ажилтан-1<br>5. Тусламж үйлчилгээнйи чанарын мэдээлэл хариуцсан мэргэжилтэн-1<br>6. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ахлах инженер-1<br>7. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер-1<br>8. Ариутгагч-1 | Бусад харилцах субъект<br>1.ЭМЯ-ны холбогдох удидлага, мэргэжилтэн;<br>2.ЭМХТ-ийн чанар магадлан итгэмжлэлийн албаны холбогдох удирдлага, мэргэжилтэн;<br>3.ЭМЯ-ны харьяа болон орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын удирдлага;<br>4.Цусны салбар төвийн эрхлэгч нар;<br>5.ЦЦБ хэрэглэгч эмнэлгийн ЦСЗЗ, ЦНЗН-ийн эмч, мэргэжилтнүүд<br>6. Гадаад, дотоодын хамтын ажиллагаатай болон хамтран ажиллах төрийн болон бусад байгууллага, иргэн. |

| V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ | |
|---|---|
| **Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:** | **Албан тушаалын тодорхойлолтыг хянасан:** |
| Албан тушаал Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны дарга<br>.................................Э.Тунгалагтуяа<br>(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)<br>2026 оны 01 дүгээр сарын 07 | Албан тушаал: Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн Хүний нөөцийн менежер<br>.................................Б.Нинжбадгар<br>(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)<br>2026 оны 01 дүгээр сарын 07 |

| **Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:** |
| --- |
| Байгууллагын нэр: Цус сэлбэлт судлалын үндэсний төв<br>Шийдвэрийн огноо: **2026.01.09**<br>Дугаар: А/03<br>(тамга/тэмдэг)<br><br>ЗАХИРАЛ............................. Б.НАРАНТУЯА<br><br>(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)<br><br>2026 оны 01 дүгээр сарын 09 |